

ЖЕНДЭРИЙН ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТ БА СУРАГЧДЫН МЭРГЭЖИЛ СОНГОЛТЫГ ФЕМИНИСТ ОГТЛОЛЦЛЫН ҮҮДНЭЭС ШИНЖЛЭХҮЙ

Доржсүрэнгийн Амартүвшин¹, доктор, Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухааны Сургуулийн Газарзүйн тэнхимийн дэд профессор

Хураангуй

Судалгаагаар сургуулийн орчин дахь жендэрийн хэвшмэл ойлголт сурагчдын мэргэжил сонголтод хэрхэн нөлөөлж байгааг Улаанбаатар хот, Говь-Алтай аймгийн улсын, хувийн, олон улсын сургуулиудын хүрээнд феминист огтлолцлын үүднээс шинжилсэн. Чанарын судалгааны фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээг MAXQDA-2022 программаар хийсэн. Судалгаанд 9-12 дугаар ангийн 58 сурагч, 13 асран хамгаалагч, эх, эцэг, багш, нийгмийн ажилтан, бодлого хэрэгжүүлэгч, төрийн бус байгууллагын төлөөлөл хамрагдсан. Сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлж буй тэргүүлэх хүчин зүйлсэд сургуулийн орчноос багш нарын заах арга барил, харилцаа, жендэрийн хэвшмэл хандлага, гэр бүл, нийгмийн зүгээс жендэрийн хэвшмэл ойлголт багтаж байна. Төвөөс алслагдах тусам сурагчдын сонгох мэргэжлийн төрөл цөөн байна. Зарим охид өндөр орлоготой, эрх мэдэл бүхий ажил мэргэжил сонирхох, эсхүл жендэрийн хэвшмэл ойлголтыг сөрж мэргэжил сонгож буй байдал ажиглагдсан. Күйр² сурагчид сургуулийн орчинд багш нар болон тогтолцооноос үүдсэн ялгаварлал, бэрхшээлтэй тулгарч байгаа нь мэргэжил сонгох хүртлээ суралцах эрхээ эдлэхэд нь саад болж байгаа ч зарим сургуулийн багш удирдлагууд күйр сурагчдад ялгаварлал багатай орчныг бүрдүүлж чадаж байна. Күйр сурагчдад тулгарч буй нийгмийн ялгаварлал нь тэдний заримыг нийгмийн энэ асуудлыг бууруулахад чиглэсэн мэргэжил рүү чиглүүлж байна. Иймд дунд сургуулийн хичээлийн агуулгад мэргэжил сонголтын хичээлийг сэргээх, багш нар, нийгмийн ажилтнууд, эцэг эх, асран хамгаалагчдыг мэргэжлийн нарийвчилсан мэдлэг, мэдээлэлтэй болгох, тэдний жендэрийн хэвшмэл хандлагыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Түлхүүр үг: Сургуулийн орчин; жендэрийн хэвшмэл ойлголт; мэргэжил сонголт; күйр сурагч

FEMINIST INTERSECTIONAL ANALYSIS OF GENDER STEREOTYPES AND CHILDREN'S PROFESSIONAL CHOICES

Abstract

The study investigates the impact of gender stereotypes on pupils' professional aspirations in public, private, and international school environments in Ulaanbaatar and Govi-Altai province of Mongolia, employing a feminist intersectionality. Empirical data were collected by in-depth interview and focus group discussion methods and were analysed using the MAXQDA-2022 program. The study included 58 children from grades 9-12, along with 13 other participants including parents, caretakers, teachers, social workers, NGO representatives, and a government officer. Key factors affecting children's professional choices were identified as teachers' teaching methods, attitudes, and gender stereotypes, alongside those prevalent in family and social settings. Students from peripheral areas exhibited a narrower range of professional aspirations compared to their urban counterparts. Some girls demonstrated resistance to stereotypical gender norms by selecting professions associated with high income and power. Queer students encountered systematic discrimination and challenges from their teachers, though instances of supportive and inclusive environments were also observed. Social stigma surrounding the queer community influenced some queer students to pursue professions aimed at addressing these societal issues. In conclusion, there is a pressing need for a module to assist students in making informed decision about their future professions. Additionally, enhancing the knowledge of teachers, parents, and caretakers regarding the diversity of professional choices is essential. Advocacy efforts to reduce gender stereotypes among educators and parents are also warranted.

Key words: School environment; gender stereotype; professional choice, aspiration; queer student

¹ Холбоо барих зохиогч. Хаяг: a.dorjsuren@num.edu.mn

² Хүйсийн баримжаа, илэрхийлэл болон, аль эсвэл бэлгийн чиг баримжааны хувьд давамгайлал соёл, нийгмийн хэм хэмжээнд багтдаггүй хүмүүсийг нэрлэдэг ерөнхий нэр томъёо.

1. ОРШИЛ

Хэвшмэл ойлголт гэдэг нь нийгмийн тодорхой бүлэгт харьяалагдах хүний талаарх төсөөлөл юм (Ellemers, 2018). Жендэрийн хэвшмэл ойлголт нь хүмүүсийг хүйсээс хамаарч ямар байх ёстойг тодорхойлсон ойлголт бөгөөд ихэвчлэн эрэгтэй, эмэгтэй байхаас хамаарч гүйцэтгэх болон хүлээх үүрэг, дүр оноох итгэл үнэмшил юм (UN, 2023). Тухайлбал өрсөлдөөнт чадвар, давамгайллыг эрэгтэй хүний шинж хэмээн үзэж, уян зөөлөн, мэдрэмтгий шинжийг эмэгтэйчүүдийн шинж гэж үзэх нь олонтаа. Энэ мэтчилэн хүний шинж чанарыг тодорхойлсон хэвшмэл ойлголт нь даамжирсаар эрэгтэйчүүдийг сонголт хийх сэтгэлгээний эрх чөлөөнд хөтөлдөг бол эмэгтэйчүүдийг нийгмийн үзэл бодлыг дагахад хөтлөн аваачдаг (Adele & Wojciszke, 2007).

Хэвшмэл ойлголтын сөрөг тал нь зөвхөн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн шинж байдлыг тодорхойлоод зогсохгүй, тэдний нийгэмд гүйцэтгэх чадамж, үүргийг хязгаарлаж, ажил мэргэжлийн сонголт, амьдралын өдөр тутмын сонголтыг хязгаарлаж байдаг (UN, 2023) (Eagly & Karau, 2002). Жендэр хэмээх нийгмийн ойлголт нь бага насанд бий болдог (Golombok & Fivush, 1994) бөгөөд үүнтэй зэрэгцэн хэвшмэл итгэл үнэмшил нь нийгмийн хэвийн үзэгдэл мэт бага нас, өсвөр насны үед бүрэлдэн тогтдог (King, Scovelle, Meehl, Milner, & Priest, 2021). Өөрөөр хэлбэл 2-5 насанд нийгмийн нөлөөгөөр жендэрийн хэвшмэл ойлголтын суурь тавигддаг (King, Scovelle, Meehl, Milner, & Priest, 2021). Эрэгтэй хүн байгалиасаа техник технологи болон тоон ухааны салбарт илүү чадварлаг гэдэг нь эмпирик үндэслэлгүй бөгөөд энэ нь тэдний мэргэжлийн хичээл ба мэргэжил сонголтоо тайлбарлах шалтгаан болохгүй. Үнэндээ ижил мэргэжлийн хичээлийг ижил байдлаар судалсан ч ажлын талбарт өөр өөр сонголт хийдэг нь тэдний өөрсдийн хэвшмэл ойлголтоос шалтгаалдаг (Favara, 2012). Хөвгүүд нийгэмд хүлээн зөвшөөрөгдөхгүй байлаа ч авьяас чадвартаа тулгуурлан мэргэжлээ сонгох нь түгээмэл байдаг бол охидын сонголтод хэвшмэл үзэл ихээхэн нөлөөлдөг (Favara, 2012). Сургуулийн орчинд хүйсээр ялгаварлах, хичээлийн агуулга, уялдааг хүйстэй холбон хэрэгжүүлэх нь охид өөрсдийн чадвараа дутуу үнэлэх, бага орлоготой ажил мэргэжлийг сонгоход түлхэц болдог.

Эрэгтэйчүүдийн хүйсийн талаарх хэвшмэл үзэл бодол нь эмэгтэйчүүд болон нонбайнари³ хүмүүсийнхээс ч илүү гүнзгий байдгийг олон улсын судалгаануудад дурдсан байдаг (Alonso-Ruido, Estévez, & Varela-Portela, 2023). Инженер, архитектурын мэргэжлийн оюутнуудад жендэрийн хэвшмэл ойлголт хамгийн их байхад урлаг, хүмүүнлэгийн ухааны салбарын оюутнуудад хамгийн бага байжээ (Alonso-Ruido, Estévez, & Varela-Portela, 2023). Харин эрх зүй, биенес удирдлагын мэргэжлийн оюутнуудад дундаж байсан байна. Энэхүү үр дүн нь *нээдүгээрт* хүйсийн харьцаатай холбогдох магадлалтай бөгөөд инженер, архитектурын мэргэжлийн эрэгтэй оюутнууд эмэгтэйчүүдээс 3 дахин их байсан. *Хоёрдугаарт* сурч буй мэргэжлийн агуулгатай холбогдож байх магадлалтай ба боловсрол, эрүүл мэндийн ухааны салбарын оюутнуудын хэвшмэл ойлголт хамгийн бага байжээ.

Kuhn, Wolter (2022) нарын судалгаагаар олон улс, тэр дундаа хөгжингүй орнуудад ч ажил мэргэжлийн хүйсийн ялгаварлал өндөр түвшинд байсаар байгаа нь харагдсан (Kuhn & Wolter, 2022). Энэ нь хөдөлмөрийн зах зээлийн бүхий л салбар, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй байгаагийн нэг шалтгаан юм.

Жендэрийн хэвшмэл ойлголт нь нийгмийн тодорхой бүлгүүдэд эерэг ба сөрөг нөлөө үзүүлдэг байна. Бага наснаас эхлэн жендэрийн үзэл баримтлалаас хамаарч ялгаатай боловсролыг олгох, тоглож буй тоглоом, сонирхон суралцах сэдвийг хязгаарладаг. Мөн гэр бүл, нийгмийн хүрээн дэх хэвшмэл ойлголтоор дамжуулан тухайн хүний хувийн хүсэл сонирхол, мэргэжил сонголт, ажлын байрны талбарт тэгш бус боломжийг бий болгох дам болон шууд нөлөөг үүсгэдэг байна.

³ Өөрийгөө гагцхүү эрэгтэй, эсвэл эмэгтэй хэмээн илэрхийлдэггүй хүнийг нэрлэдэг тэмдэг нэр. Нонбайнари хүмүүс өөрийгөө эрэгтэй, эмэгтэй аль алианаар нь, аль эсвэл хоёр хүйсийн дунд хаа нэгтээ, эсвэл аль алианаар нь ч илэрхийлэхгүй байж болно. Түүнчлэн нонбайнари нь ажендэр, бижендэр, жендэркүйр, жендэрийн хувьд хувьсамхай гэх зэрэг илэрхийллүүдийг багтаасан ерөнхий нэр томъёо.

Энэ судалгаагаар сургуулийн орчин дахь жендэрийн хэвшмэл ойлголт хүүхдүүдийн мэргэжил сонголтод хэрхэн нөлөөлж байгааг сурагчид, боловсролын салбарт ажиллагсад болон хүүхдийн асран хамгаалагчдын үзэл бодол, байр суурьт үндэслэн судалж илрүүлэхийг зорьсон. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд дараахь зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

1. Жендэрийн хэвшмэл ойлголтын талаарх суурь судалгаа болон бусад эх сурвалжид тулгуурлан судалгааг удирдан явуулах онолын үзэл баримтлалын хүрээг тодорхойлох;
2. Монгол Улсын хот, суурин, орон нутгийн хүүхдүүдийн сургуулийн орчин дахь жендэрийн хэвшмэл ойлголт мэргэжил сонголтод хэрхэн нөлөөлж байгааг шинжлэх;
3. Сургуулийн орчинд жендэрийн хэвшмэл ойлголтын нөлөөг бууруулах, сурагчдыг жендэрийн эрх тэгш орчинд мэргэжил сонгоход чиглэсэн санал зөвлөмж боловсруулах

Сэдвийн судлагдсан байдлын хүрээнд олон улс дахь жендэрийн хэвшмэл ойлголтын талаарх ойлголт, мэргэжил сонголт, жендэрийн цалингийн ялгааг тодруулж улмаар Монгол Улс дахь жендэрийн хэвшмэл ойлголт, боловсролын салбар болон хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн ялгаатай байдал, олон нийтийн мэдээллийн хэрэгслээрх жендэрийн хэвшмэл ойлголтын агуулгын талаар тоймоллоо. Энэ нь жендэрийн хэвшмэл ойлголт сурагчдын мэргэжил сонголтод хэрхэн нөлөөлөх үзэл баримтлалын суурь болов.

2. СУДЛАГДСАН БАЙДАЛ: ЖЕНДЭРИЙН ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТ БА ҮР ДАГАВАР

2.1. Монгол Улс дахь жендэрийн хэвшмэл ойлголт

Жендэрийн тухай ойлголт, түүний үндсэн чиг баримжааг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид тусган өгөхдөө:

“жендэрийн эрх тэгш байдал” гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх”-ыг онцолжээ (УИХ, 2011).

Энэ нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс ижил түвшинд сурч боловсорч, адил хөдөлмөр эрхэлж, хөдөлмөрөө үнэлүүлэх, эрүүл мэндээ хамгаалуулах тухай ойлголт юм. Жендэрийн талаар баримтлах үндэсний бодлогод тодорхойлсноор жендэрийн хэвшмэл ойлголт гэдэг нь “Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн шинж төрх, байр суурь, гүйцэтгэх үүргийн талаарх хувь хүмүүсийн ялгаатай байдал, цаг хугацаан дахь өөрчлөлтийг үл тооцсон хялбаршуулсан ойлголт төсөөлөл, явцуу итгэл үнэмшил, хүлээлт юм. *Хэвшмэл ойлголт нь эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг бодлого төлөвлөлтөд анхаарч тусгахад садаа болж, шударга бус хандахын, аливаа шударга бус байдлыг зөвтгөхийн үндэс болж байдаг*” ажээ (Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Яам, 2018).

Жендэрийн тэгш байдлын үзүүлэлтээр Монгол Улс 2018 онд дэлхийн улс орнуудаас 58 дугаарт орж байсан ч 2020 онд 79 дүгээрт орж ухарсан нь жендэрийн хэвшмэл ойлголтөөс улбаалсан сөрөг нөлөө даамжирсаар байгаагийн нэг илрэл гэж болно (Жендэрийн Үндэсний Хороо, 2020). Олон улсад эмэгтэйчүүд эдийн засгийн асар их чадавхтай ба монгол эмэгтэйчүүд ч үүнд хамаарна. Гэвч Монгол Улсад эмэгтэйчүүд өөрсдийн чадавхыг бүрэн ашиглахад олон жил уламжлагдаж ирсэн эмэгтэй хүний талаарх хэвшмэл үзэл ихээхэн саад бэрхшээл учруулдаг байх магадлалтай байна (Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, 2021а).

Гүйцэтгэх шатны албан тушаалаас эхлээд бодлого, шийдвэр гаргагчдын түвшин хүртэл бүхий л шатанд жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт сул байна. Жендэрийн хэвшмэл ойлголтод тулгуурласан шийдвэрийг гаргасаар байгаа нь нийгмийн асуудлуудыг гүнзгийрүүлсээр байна. Монгол Улсад мөрдөж буй зарим хууль тогтоомж нь эмэгтэйчүүдийн тэтгэврийн насыг эрт тогтоох байдлаар эмэгтэйчүүдийн эдийн засгийн нөөц боломжийг бүрэн ашиглахад саад болдог (UNDP, 2021). Газар өмчлөх нь эмэгтэйчүүдээс илүү эрэгтэйчүүдэд түгээмэл байгаа, хүүхэд асрах стандарт хангасан чанартай дэд бүтэцгүй, цалин хөлсгүй ажлыг

эмэгтэйчүүд олноор хийж байгаа зэрэг асуудлууд эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бүрэн ашиглахад бэрхшээл учруулж байна (Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, 2021а)

Боловсролын салбарын хувьд, 2018 онд Монгол Улсын их дээд сургууль, коллежид 64 мянган эрэгтэй, 93 мянган эмэгтэй суралцаж байв. Харин техник болон мэргэжлийн боловсролд 22 мянган эрэгтэй, 14 мянган эмэгтэй суралцаж байжээ. Эмэгтэйчүүдийн их, дээд сургуульд хамрагдаж буй түвшин эрэгтэйчүүдээс их боловч эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 12 хувиар илүү байна (Жендэрийн Үндэсний Хороо, 2020). Ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-д өдрөөр суралцагчдын тооны харьцаа бараг тэнцүү буюу 291 мянган эрэгтэй, 289 мянган эмэгтэй байна. ЕБС-ийн сурагчдын хүйсийн харьцаа бараг жигд байгаа боловч их, дээд сургуульд суралцагчдын дунд охидын тоо давамгайлж, харин техник, мэргэжлийн боловсрол эзэмшиж буй суралцагчдын дунд эрэгтэйчүүд харьцангуй олон байна. Түүнчлэн Болдмаа нар (2019)-ын судалгаагаар их дээд сургуулийн оюутнуудын дунд жендэрийн хэвшмэл ойлголт түгээмэл байгаа нь эрэгтэй хүүхэд техник байгалийн ухааны хичээлд сайн (63.1%), эмэгтэй хүүхэд хэл, нийгмийн ухааны хичээлд сайн (49.7%) хэмээн хүлээн зөвшөөрсөн хандлагаас харагдаж байна (Болдмаа, Чанцалдулам, Галиймаа, & Одгэрэл, 2019).

2.2. Хөдөлмөрийн салбар дахь жендэрийн харьцаа

Монгол Улсын эдийн засгийн салбаруудад ажиллагчдын статистик тоог 2010 ба 2020 оны байдлаар харьцуулж Хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1: Монгол Улсын эдийн засгийн салбарт ажиллагчдын хувь, хүйсийн бүтцээр, 2010 ба 2020 он

№	Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Хүйс	2010	2020	Зөрүү
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	Эрэгтэй	54.4	55.8	1.4
		Эмэгтэй	45.6	44.2	-1.4
2	Уул уурхай, олборлолт	Эрэгтэй	77.5	82.5	5.0
		Эмэгтэй	22.5	17.5	-5.0
3	Барилга	Эрэгтэй	77.6	85.4	7.7
		Эмэгтэй	22.4	14.6	-7.7
4	Мэдээлэл холбоо	Эрэгтэй	50.5	53.7	3.2
		Эмэгтэй	49.5	46.3	-3.2
5	Санхүү, даатгалын үйл ажиллагаа	Эрэгтэй	37.2	34.9	-2.3
		Эмэгтэй	62.8	65.1	2.3
6	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Эрэгтэй	65.5	60.2	-5.3
		Эмэгтэй	34.5	39.8	5.3
7	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа	Эрэгтэй	58.6	53.6	-5.0
		Эмэгтэй	41.4	46.4	5.0
8	Боловсрол	Эрэгтэй	28.2	26.8	-1.3
		Эмэгтэй	71.8	73.2	1.3
9	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	Эрэгтэй	21.5	21.3	-0.2
		Эмэгтэй	78.5	78.7	0.2
10	Мэргэжлийн шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагаа	Эрэгтэй	50.6	60.0	9.5
		Эмэгтэй	49.4	40.0	-9.5

Эх үүсвэр: (Үндэсний Статистикийн Хороо, 2023)

Хүснэгт 1-ээс, 10 жилийн хугацаанд хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүч тасралтгүй өссөн нь харагдаж байна. Харин нийт 10 салбарын тавд нь эмэгтэй ажиллагчдын харьцаа

буурч, тавд нь нэмэгджээ. Үүнээс шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагааны салбар (-9.5%), барилга (-7%), уул уурхай, олборлолт (-5%) гэсэн салбаруудад эмэгтэйчүүдийн оролцоо хамгийн их хувиар буурчээ. Харин төрийн албан хаагчдын дотор эмэгтэйчүүд 60.4 хувийг (Жендэрийн Үндэсний Хороо, 2018) эзэлж байгаа ч төрийн удирдлагын шатанд тэд 46 хувийг эзэлж байна. Хөдөө аж ахуй, уул уурхай, барилгын салбарт эрэгтэйчүүдийн тоо давамгайл байхад санхүү, даатгал, боловсрол болон эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагааны салбар дахь эмэгтэйчүүдийн тоо эрчүүдээс олон байна. Энэ нь аливаа мэргэжлийг сонгоход жендэрийн хэвшмэл ойлголт шууд нөлөөлж буйг илэрхийлж байх магадлалтай. Аливаа салбарт аль нэг хүйс давамгайлж, хоорондын тооны зөрүү ихсэх тусам жендэрийн тэгш бус байдал, боловсролын тэгш бус байдал төдий чинээгээр нэмэгдэж, эдийн засгийн ялгаатай байдал даамжирч байна (Болдмаа, Чанцалдулам, Галиймаа, & Одгэрэл, 2019).

Монгол Улсын эрүүл мэндийн салбарт ажиллагчдын 78.7 хувь, боловсролын салбарын ажиллагчдын 73.2 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна (Жендэрийн Үндэсний Хороо, 2022). Цар тахлын үеэр охид, эмэгтэйчүүдийн гэрийн ажил нэмэгдсэн нь охидын боловсролд тэгш хамрагдах боломжийг бууруулжээ. Мөн гэрийн ажил, хөлсгүй хөдөлмөрийн ачаалал нэмэгдэж, нийгмийн харилцаа багассан нь эмэгтэйчүүдийн сэтгэцийн эрүүл мэндэд ч сөргөөр нөлөөлсөн байна (Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, 2021b). Малчин өрх, тэдний гэр бүлийн эмэгтэй гишүүд цар тахлын нөлөөнд илүүтэй өртсөн бөгөөд хичээлийг теле хэлбэрт шилжүүлснээр хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг нь улам ихэсчээ (Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, 2021b).

Эдийн засгийн зарим салбарт жендэрийн харьцаа илт зөрүүтэй байгааг дараах байдлаар тодруулах шаардлагатай байна. Үүнд:

- Сургууль, гэр бүл, нийгмийн орчин дахь жендэрийн хэвшмэл ойлголт мэргэжил сонголтод хэрхэн нөлөөлж байгаа,
- Сурагчдын мэргэжил сонголт ба мэргэжлийн талаарх мэдлэг, ойлголт түүний хүртээмж,
- Жендэрт суурилсан хөдөлмөрийн зах зээлийн хуваагдлыг бий болгож буй бусад хүчин зүйл зэргийг судлан үзэж, танин мэдэх.

2.3. Мэргэжил сонголт

Мэргэжил сонголт хэд хэдэн дараалсан шийдвэрүүдийн цогц үйл явц юм. Хүмүүс ажил мэргэжил, карьераа сонгохдоо өөрсдийн хүсэл сонирхол, хэрэгцээгээ хангах зорилготой байхын зэрэгцээ ажлын талбарт тулгарч болох бэрхшээлүүдийг ч харгалзан үздэг (Ginzberg, 1972). Мэргэжил сонголт хамгийн их нөлөөлөгч хоёр орчны нэгдүгээрт гэр бүлийн орчин, хоёрдугаарт сургуулийн орчин багтдаг.

Өсвөр насныхны гэр бүл, ялангуяа тэдний эцэг эхийн илэрхийлдэг хүсэл, хүлээлт нь хүүхдийн мэргэжил сонголтод хүчтэй нөлөөлдөг. Тухайлбал, эцэг эхчүүд i) өөрийн ажил мэргэжлийн талбартаа хүссэн шигээ өндөрлөгт хүрч чадаагүй бол хүүхдээ хүргэх гэж тулгадаг; ii) өөрийн ажил мэргэжлийн талбартаа өндөр амжилттай ажиллаж, өөрийн хүүхдээ ч адил замналаар явахыг ятгаж, бусад талбарт амжилттай ажиллаж чадахгүй хэмээн тулгадаг. Харин сургуулийн орчин талаас харвал, i) өөрийн болон өрөөл бусад чухал хүмүүсийн харилцаа, хамаарал; ii) ажил мэргэжил, хүсэл эрмэлзлийн тухай мэдлэг, мэдээлэл; iii) өөрийгөө танин мэдэж карьераа уялдуулан ойлгох; iv) боловсролын үр нөлөө зэрэг нь мэргэжил сонголтын чухал суурь болдог байна.

3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

3.1. Судалгааны онол, арга зүйн үндэслэл

Судалгаанд феминист огтлолцлын (intersectional) шинжилгээний онол, арга зүйг ашигласан. Энэ нь нийгмийн аливаа асуудлыг харах, шинжлэх хүрээ бөгөөд жендэр, арьс, нийгмийн байр суурь болон бусад суурь хүчин зүйлсийн огтлолцолд аливааг шинжлэх үзэл баримтлал юм (Crenshaw, 1991). Иймд судалгаанд жендэрийн байнари буюу эрэгтэй эмэгтэй хэмээх хоёр туйлт үзлээс хальж күйр төлөөллийг судалгаанд хамрууллаа. Мөн сургуулийн газарзүйн байрлал, өмчийн хэлбэрийг харгалзаж илүү олон огтлолцол дахь амьдралын түүхийг цуглуулахыг эрмэлзсэн болно.

Сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тодорхойлохдоо судлагдсан байдлын тоймд үндэслэн үндсэн нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлсон. Судалгаа сургуулийн орчин дахь жендэрийн хэвшмэл ойлголт сурагчдын мэргэжил сонголтод хэрхэн нөлөөлж байгааг судлах зорилго агуулсан ч гэр бүлийн орчин чухал болохыг бусад судалгаанууд мөн онцолж байсан. Иймд хүүхдийн мэргэжил сонголтод нөлөөлөгч хүчин зүйлсийг дараах хүчин зүйлсийн хүрээнд тоймлож, судалгааны асуултын суурь болголоо. Үүнд:

1. Сургуулийн орчин дахь жендэрийн хэвшмэл ойлголт
2. Гэр бүлийн орчны жендэрийн хэвшмэл ойлголт
3. Сурагчдийн мэргэжил сонголтыг дэмжих арга хэмжээ
4. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээрх жендэрийн хэвшмэл ойлголтын мэдээлэл
5. Газарзүйн болон байршлын онцлог
6. Сургуулийн өмчийн хэлбэр
7. Бодлогын шийдвэрүүд
8. Бусад

3.2. Судалгааны загвар

Жендэрийн хэвшмэл ойлголт сурагчдын мэргэжил сонголтод хэрхэн нөлөөлж байгааг судлах судалгааны мэдээлэл цуглуулалтын гол хэрэгсэл нь чанарын судалгааны хагас бүтэцлэгдсэн асуулга буюу ярилцлагын удирдамж асуултууд байв. Чанарын судалгааны хагас бүтэцлэгдсэн асуулгаар ярилцлага хийх нь судалгааны сэдвийн хүрээнд урьдаар төлөвлөсөн асуултуудыг асууж, судалгаанд оролцогчийн байр суурь, үзэл бодол, амьдралын туршлагыг сонсож, харилцан ярилцах арга юм. Ялангуяа яагаад, хэрхэн, яаж хэмээх шалтгаан заасан асуултуудыг лавшруулсан асууснаар тоон судалгаагаар илрүүлэх боломж багатай зүйлсийг судалдаг онцлогтой. Хагас бүтэцлэгдсэн учир судалгааны явцад шинээр илэрч буй асуудлуудын талаар нэмж, дэлгэрүүлж ярилцаж болдог уян хатан арга юм. Судалгаанд бэлтгэхийн тулд сэдэвтэй холбоотой судлагдсан байдлыг тоймлон, жендэрийн хэвшмэл ойлголтыг тодорхойлж, хот, суурин орон нутгийн нийгмийн амьдралын ялгаатай байдал сурагчдын мэргэжил сонголтыг хэрхэн нөхцөлдүүлж болох шалтгааныг илрүүлэх асуултуудыг тоймлов.

Сэдэвтэй холбогдуулж сурагчдааас гадна багш, эцэг эх, асран хамгаалагч, сургуулийн нийгмийн ажилтан, судлаач, иргэний нийгмийн байгууллага, бодлого боловсруулагчдын төлөөллөөс чанарын судалгааны ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан.

Мэдээлэл цуглуулалтыг 2023 оны 9 сарын 15-наас 12 сарын 11-ны хооронд гүйцэтгэсэн ба сумын төв, аймгийн төв, нийслэл гэсэн ялгаатай байршлуудаас сурагчдыг түүвэрлэн сонгож хамруулсан. Судалгаанд оролцогчдыг сонгохдоо магадлалт бус түүврийн хэд хэдэн аргыг хослуулж ашигласан. Нэгдүгээрт, “цасан бөмбөлөг хийх” аргыг ашигласан бөгөөд ингэхдээ судалгааны зорилго танилцуулж, эхний оролцогчоор дараагийн боломжит оролцогчийг заалган илрүүлж, холбогдох байдлаар бүрдүүлэв. Судалгаанд оролцогчдын санал болгож

буй хүнийг сонгохдоо тэдний гэр бүл, найз нөхөд, шууд хамааралгүй байх хүнийг сонгохыг эрмэлзсэн. Мөн дунд сургуулийн багш, нийгмийн ажилтанд судалгааны зорилгоо танилцуулж, судалгаанд оролцох сурагчдыг сонгосон. ЛГБТИК+⁴ оролцогчидтой ЛГБТ Төвөөр дамжуулж холбогдсон. Судалгаанд оролцохоор сонгогдсон хүүхдүүдэд судалгааны зорилгоо танилцуулж, өөрийнх нь болон асран хамгаалагчийн зөвшөөрөлтэйгээр судалгаанд хамруулав. Түүврийн үндсэн шалгуурт (i) газарзүйн ялгаатай байршил; (ii) төр, хувийн хэвшлийн сургууль; (iii) хүйсийн олон талт байдал; (iv) сурагчийн багш, гэр бүл, асран хамгаалагч байх шалгуурыг чухалчлав.

3.3. Судалгааны түүвэр

Судалгаанд газарзүйн хувьд ялгаатай хоёр байршлыг (Улаанбаатар хот, Говь-Алтай аймаг) сонгохдоо санхүүжилт, цаг хугацааны хүчин зүйлст хязгаарлагдав. Улаанбаатар хотыг судалгааны талбараар сонгохдоо 1.4 сая хүн амтай, Монгол улсын хамгийн олон оршин суугчтай хот болохыг харгалзсан. Учир нь хотын хүн ам өсөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор нийслэлд сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг нийгмийн дэд бүтцийн хүртээмж багасч шинээр суурьшсан хотын оршин суугчид орон сууц, ажил эрхлэлт, хүүхдийн боловсролын үйлчилгээтэй холбоотой төрөл бүрийн бэрхшээлтэй тулгардаг. Тиймээс Улаанбаатар хотын хүүхдүүд гэр бүлийн нөхцөл байдал, байршлаасаа шалтгаалаад олон янзын сорилтуудтай тулгардаг байж болзошгүй гэж үзсэн.

Говь-Алтай аймаг нь судалгааны хоёр дахь талбар бөгөөд Улаанбаатар хотоос 1 001 км зайтай, алсагдсан аймгуудыг төлөөлж сонгогдсон. Аймгийн төв, сумын төв, орон нутгийн малчдын хүүхдүүд нүүдлийн соёл, өдөр тутмын амьдрал дахь улирлын онцлогоос шалтгаалан өөр өөр амьдралын нөхцөлтэй тулгардаг. Иймд хязгаар нутгийг сонгох нь тэнд хүүхдүүд хэрхэн сургуульд хамрагддаг, цаашид суралцах мэргэжлээ хэрхэн сонгодог арга замыг судалж судалгааны үр дүнг баяжуулах боломжтой. Алслагдсан газарт уламжлалт соёл, түүний үнэт зүйлс хүүхдүүдийн мэргэжлийн сонголтод нөлөөлдөг байх магадлалтай юм.

Судалгааны хүрээнд ганцаарчилсан 19, бүлгийн 18, нийт 37 удаагийн ярилцлага хийсэн ба 58 ахлах ангийн (IX-XII анги) сурагчид, мөн 13 эцэг эх, нийгмийн ажилтан, багш, бодлого боловсруулагч, иргэний нийгмийн төлөөлөл, нийт 71 оролцогч хамрагдсан. Түүврийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 2, Хүснэгт 3, Хүснэгт 4-т харуулав.

Улаанбаатар хот, аймгийн төв, сумын төвийн хүн амын тоо харилцан адилгүй тул түүврийн нийт тоог хүн амын тоотой уялдуулж тогтоолоо. Гэхдээ түүврийн загвар нь магадлалт бус тул ялгаатай байдлын төлөөлөл оролцуулахыг илүү чухалчлав.

Газарзүйн байршил нь сурагчдын боловсролын үйлчилгээг авах болон нийгмийн харилцаанд оролцоход саад, дэм болох гол хүчин зүйлсийн нэг тул байршлыг онцлов. Мөн өмчийн хэлбэрээс хамаарч сургуулиудын хичээлийн агуулга, заах арга, хичээлээс гадуур сурагчдыг хөгжүүлэх орчин ялгаатай байдаг тул өмчийн гурван өөр хэлбэрийн сургуулийг сонгосон. Тиймээс судалгаанд хамрагдах сурагчдын суралцаж буй сургуулийг сонгохдоо Улаанбаатар хот, Говь-Алтай аймгийн улсын, хувийн болон олон улсын сургуулийг хамруулав (Хүснэгт 3). Сургуулийн болон суралцагчдын төвөөс алслагдсан байдлыг Улаанбаатар хотын хувьд төвийн, захын, дундын байршлыг харгалзаж үзсэн. Ерөнхий боловсролын нийт 31 сургуулиас төрийн өмчит 23, хувийн 7, олон улсын 1 сургуулийн 58 сурагчид судалгаанд хамрагдлаа. Үүнд Говь-Алтай аймгийн төв Есөнбулаг сумын 5 сургуулийн 19 сурагч, Баян-Уул сумын 1 сургуулийн 6 сурагч, Улаанбаатар хотын 25 сургуулийн 33 сурагч байв. Хүүхдүүд IX анги төгсөөд МСҮТ болон ахлах ангид суралцахаар шийддэг тул 9 -12 ангийн сурагчдыг судалгаанд хамруулав.

⁴ Лесбиян, гей, бисексуал, трансжендэр, күйр, интерсекс болон "+" тэмдгээр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн хязгааргүй олон янз байдлыг илэрхийлэн нэрлэдэг товчилсон үг юм.

Хүснэгт 2: Сурагчдын түүврийн хэмжээ, ярилцлагын хэлбэрээр, хүйсээр

Оролцогчдын төрөл	Ганцаарчилсан ярилцлага	Бүлгийн ярилцлага	Нийт
Эрэгтэй (сисжендэр) оролцогчидтой	10	2	12
Эмэгтэй (сисжендэр) оролцогчидтой	9	2	11
Эмэгтэй, эрэгтэй оролцогчидтой (сисжендэр)	-	13	13
Нонбайнари күйр, трансжендэр ⁵ эмэгтэй, күйр эрэгтэй	-	1	1
Нийт	19	18	37

Хүснэгт 3: Сурагчдын түүврийн хэмжээ, байршил, сургуулийн өмчийн хэлбэр, хүйсээр

Оролцогчдын төрөл	Сургуулийн байршил ба өмчийн хэлбэр					Нийт
	Улаанбаатар хотын сургууль			Говь-Алтай аймгийн төв	Говь-Алтай аймгийн Баян-Уул сум	
	Улсын өмчийн	Хувийн өмчийн	Олон улсын	Улсын өмчийн	Улсын өмчийн	
Эрэгтэй (сисжендэр)	10	4	1	5	3	23
Эмэгтэй (сисжендэр)	11	2	2	14	3	32
Жендэр күйр	2	1	-	-	-	3
Нийт						58

Хүснэгт 4: Сурагчдаас бусад түүврийн хэмжээ, байршил, төлөөллийн хэлбэрээр

Төлөөллийн хэлбэр	Улаанбаатар хот	ГАА, Есөнбулаг сум	ГАА, Баян-Уул сум	Нийт
Сургуулийн нийгмийн ажилтан	1	1	1	3
Багш	1	2	1	4
Эх	0	1	1	2
Эцэг	0	1	1	2
Бодлого боловсруулагч	0	1	0	1
ТББ-ийн төлөөлөл	1	0	0	1
Нийт				13

3.4. Өгөгдлийн шинжилгээ

Ярилцлагуудыг хөрвүүлж MAXQDA-2022 програмын тусламжтайгаар кодлож, дүн шинжилгээ хийсэн бөгөөд фрэймвөрк шинжилгээний аргыг ашиглан ярилцагчийн хэлсэн үгийн утга санаа, агуулга, холбоос мөн нуугдмал утгад шинжилгээ хийсэн. Ингэхдээ хөрвүүлсэн ярилцлагыг ойлгож, гол сэдвүүдийг тодруулан, кодложхоорондын уялдааг зураглаж, тайлбарлан шинжлэв (Ritchie & Lewis, 2006). MAXQDA-2022 програмд нийт мэргэжил, сурагчид, багштэй холбоотой 45 код үүсгэсэн. Ингэхдээ сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлөгч хүчин зүйлсийг ажлын нөхцөл, цалин, дадлагажсан байдал, хүсэл сонирхол, амьдралын асуудал, багш, сурагч, гэр бүлийн гишүүд, нийгийн жендэрийн хэвшмэл ойлголт гэх мэтээр кодлож, хамгийн түгээмэл давтамжаар сэдэвчилж шинжлэв.

⁵ Төрөх үед тэмдэглэгдсэн хүйстэй холбоотой давамгайлал соёл, нийгмийн хүлээлтээс өөр хүйсийн баримжаа, илэрхийлэлтэй хүмүүсийг нэрлэдэг ерөнхий нэр томьёо.

3.5. Судалгаанд баримталсан ёс зүй

Судалгаанд оролцогчийг ярилцлагад урихдаа судалгааны талаар танилцуулж, тэдний эх, эцэг, асран хамгаалагчдаас утсаар зөвшөөрөл авсны дараа сурагч өөрөө зөвшөөрвөл ярилцлагуудыг гүйцэтгэв. Уг судалгаанд оролцсоноор хэн нэгний нэр төр, алдар хүнд сэвтэх, хувийн болон байгууллагын нууц алдагдахаас сэргийлж оролцогчдын нэр, сургуулийн нэрийг анализ хэсэгт дурьдаагүй. Мөн ярилцлагын үед дурьдагдсан хүний нэрийг нууцалж *** тэмдэглэгээгээр орлуулав. Зарим сурагчид, оролцогчид судалгааны үед амьдралын таагүй дурсамж нь сэдэрх, цочрохоос сэргийлж хүнд сэдвийг хөндсөн үед тайвшруулж, хандаж болох сэтгэлзүйчтэй холбогдох утасны дугаарыг санал болгож байсан. Судлаачид өөрсдийн хувь хүний субъектив хандлагаа байж болох хамгийн бага түвшинд байлгаж судалгааг гүйцэтгэсэн.

3.6. Судалгааны хязгаарлагдмал байдал

Энэхүү судалгаанд оролцох зарим сурагчийг сонгохдоо сургуулийн багш, нийгмийн ажилчдаар дамжуулж сонгосон бөгөөд энэ нь хамгийн идэвхтэй сурагчдыг сонгосон байх магадтай юм. Иймд судлаачид зарим сурагчийг өөрсдөө сонгон дээрх болзошгүй гажуудлыг бууруулахыг зорьсон. ЛГБТИК+ олон нийтийн төлөөллийг сонгохдоо ЛГБТ Төвөөр дамжуулж сонгосон бөгөөд энэ нь нээлттэй бус, өөрийнхөө бэлгийн болон жендэрийн баримжаагаа бүрэн таниагүй сурагчдын төлөөллийг орхигдуулсан байх талтай. Мөн күйр сурагчдын төлөөлөл зөвхөн Улаанбаатар хотоор хязгаалагдсан нь орон нутагт амьдардаг күйр сурагчийн туулж буй туршлагыг орхигдуулсан байх талтай юм. Судалгааны өгөгдлийг судлаачид тус тусдаа бичвэр болгон хөрвүүлэхдээ сул үгсийг орхиж, оролцогчдын ярьсан гол утга санааг утгын алдаагүй буулгахаар хичээн ажилласан ч зарим нэг ташаарал гарсан байх магадтай юм.

4. СУДАЛГААНЫ ҮР ДҮН БА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Дунд сургуулийн сурагчдын мэргэжил сонголтод гэр бүл, нийгмийн орчин суурь нөхцөлдүүлэгч хүчин зүйл болж байна. Үүний зэрэгцээ шат, шатны боловсролын байгууллагын багш нарын мэдлэг, чадвар, хандлага, сургалтын хөтөлбөр болон сургуулийн өмчийн хэлбэр, зохион байгуулалт мэргэжил сонголтод голлох нөлөөтэй байна. Сургуулийн орчин нь гэр бүл, нийгмийн тусгал тул сурагчид сургуулийн орчинд гэр бүл, нийгмийн нөлөөг түгээж, жендэрийн зарим хэвшмэл ойлголтыг батжуулж, хэвшүүлж байна. Энэ дотроос багш, эх, эцэг, асран хамгаалагчид, ажил олгогчдын жендэрийн хэвшмэл ойлголт зарим талаар мэргэжил сонголтод нөлөөлж байгаа нь ажиглагдлаа. Боловсролын тогтолцоо жендэрийн эрх тэгш байдлын хувьд байнари хүрээнд зохион байгууллагдаж байгаа нь жендэр күйр сурагчдад зарим талаар сорилт, бэрхшээл болж нөгөө талаар цөөн тохиолдолд багш нар болон гэр бүлийн гишүүдийн дэмжлэгтэйгээр энэ сорилтыг даван туулж байна. Судалгааны үр дүнг дараах хэсэгт дэлгэрүүлж танилцуулав.

Судалгаанд оролцсон 58 сурагчийн 55.2 хувь эмэгтэй, 39.7 хувь эрэгтэй, 5.2 хувь нь күйр сурагчид байв. Суралцаж буй сургуулиар ангилвал 82.8 хувь нь улсын, 12.1 хувь нь хувийн, 5.2 хувь нь олон улсын сургуулийн сурагчид байсан. Улсын сургуулиас судалгаанд хамрагдагчдын 58.3 хувь охид байсан бол хувийн сургуулиас судалгаанд оролцогчдын 57.1 хувь нь хөвгүүд, 14.3 хувь нь күйр төлөөлөл байлаа. Олон улсын сургуулиас күйр төлөөлөл байгаагүй.

Судалгаанд оролцсон нийт эрэгтэй (32), эмэгтэй (23) сурагчдын мэргэжил сонголтын байдлыг эрэмбэлхэд эхэнд нь мэдээллийн технологийн инженер байв. Удаах сонголт охидын хувьд анагаах ухаан, сэтгэлзүйчийн мэргэжил (тус бүр 9) байна. Хөвгүүдийн хувьд удаах сонголт нь анагаах ухаан (10) байна. Күйр сурагчид (3) хуульч, социологич, олон улсын харилцаа гэх нийгмийн ухааны мэргэжлийг сонгожээ. Мэргэжил сонголтын хувьд жендэрийн хэвшмэл ойлголт төдийлөн хамааралгүй мэт ажиглагдаж байна.

Газарзүйн байршлаар ангилж үзвэл хотын сурагчдын хувьд олон янзын мэргэжил (12 бүлэгт хамаарах) сонгосон бол аймгийн төвийн сурагчид хотын сурагчдаас цөөн (6 бүлэгт хамаарах) боловч сумын төвийн сурагчдаас (4 бүлэгт хамаарах) олон төрлийн мэргэжил сонгосон байна. Сумын төвийн сурагчид цөөн тооны мэргэжил (мэдээллийн технологи, анагаах ухаан, сэтгэлзүйч, архитектор), хотын сурагчид олон төрлийн мэргэжил сонгож байгаа нь түүврийн тооны зөрүү болон мэдээллийн ялгаатай хүртээмж хэмээх хоёр үндсэн шалтгаантай байж болох юм.

Их, дээд сургуульд элсэхээр төлөвлөж буй улсын сургуулийн сурагчдын (23) хамгийн олон (11) нь мэдээлэл технологийн салбарыг сонгон элсэх сонирхолтой байна. Нийт сурагчдаас сэтгэл зүйч, анагаах ухааны мэргэжлүүдийг тус бүр 4 сурагч сонгон суралцах төлөвтэй байна. Улсын сургуулийн сурагчид нь мэдээлэл технологи, сэтгэл судлал, анагаах ухааны мэргэжлүүдийг түлхүү сонгожээ. Тухайн элсэгчдийн дунд охид давамгай байгаа ч тэд цөөн тооны мэргэжлүүдээс сонгож буй дүр зураг харагдаж байна. Анагаах ухаан, сэтгэл судлалын мэргэжлүүдийн хувьд түгээмэл байдаг буюу олон нийтэд танигдсан байдал нь нэгдүгээрт томоохон нөлөө үзүүлж байж магадгүй. Мөн тухайн мэргэжлийг сонгогчдын дунд охид давамгайлж байгаа нь “охид нийгмийн суурьтай, харилцан ярилцдаг мэргэжил эзэмших хэрэгтэй, эмэгтэй хүүхэд зөөлөн гартай учраас эмч болох хэрэгтэй” гэх мэт нийгэмд түгээмэл байдаг жендэрийн хэвшмэл ойлголтоос үүдсэн байж болох юм. Мэдээллийн технологийн мэргэжлийн хувьд цалин хангамж, ажлын байрны орчноос хамаарсан эрэлт байж болох юм. Учир нь тухайн салбарын боловсон хүчин нь бусад салбараас бага цагаар өөрийн хүссэн орчноос ажиллаж, өндөр орлого олох боломжтой гэдэг ойлголт нийгэмд түгээмэл байдаг нь тус судалгааны явцад ажиглагдаж байсан.

Судалгаанд хамрагдсан хувийн сургуульд суралцагч хүүхдүүд (7) мэдээллийн технологи, инженер, улс төр, цэрэг цагдаагийн мэргэжлийг сонгожээ. Охид инженерийн болон улс төрийн чиглэлийн мэргэжлүүдийг тэнцүү хувьтай сонгожээ. Хувийн сургуулийн сурагчдын дунд мэргэжил сонгоход жендэрийн хэвшмэл ойлголт бага ажиглагдлаа. Тухайлбал охид түгээмэл сонгодог анагаах ухааны мэргэжлийг зөвхөн хөвгүүд сонгосон байхад хөвгүүд түгээмэл сонгодог инженерийн салбарыг зөвхөн охид сонгожээ. Хувийн сургуульд улсын сургуулийн сурагчдаас ялгаатай нь инженерийн мэргэжлээр суралцах хүсэл сонирхолтой эмэгтэй сурагчдын тоо өндөр байна. Энэ нь хувийн сургуулиудын дотоод орчин, сургалтын хөтөлбөр эсвэл хувь сурагчийн хүсэл тэмүүлээс шалтгаалсан байж болно. Олон улсын хөтөлбөртэй сургуулийн сурагчдын (3) хувьд архитектур, анагаах ухаан, бизнесийн мэргэжлүүдийг сонгон суралцана гэжээ. Сургуулийн өмчийн хэлбэрээр ангилж үзэхэд улсын сургуулийн сурагчдын мэргэжил сонголтод жендэрийн хэвшмэл ойлголт илүү нөлөөлж байж магадгүй тал ажиглагдлаа.

4.1. Сургуулийн орчин сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлөх нь

Сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлөгч хүчин зүйлсийг шинжлэхдээ судлаачдын субъектив нөлөөг бууруулах үүднээс MAXQDA 2022 програм дээрх кодуудыг ашиглан хүчин зүйлсийн давтамжийг тооцов. Сурагчдын мэргэжил сонголтод хамгийн олон удаа дурдагсан дараах хүчин зүйлс байв (хаалтанд давтамжийг илэрхийлэв):

1. Багшийн хандлага (67),
2. Тухайн мэргэжлийн ажиллах орчин нөхцөл (61),
3. Сурагчийн тухайн мэргэжилд тэмүүлэх сонирхол (53),
4. Нийгэм дэх жендэрийн хэвшмэл ойлголт (42),
5. Сурагчдын жендэрийн хэвшмэл ойлголтыг үл зөвшөөрөх байдал (42) эсхүл зөвшөөрөх байдал (29),
6. Сурагчийн хувь хүний онцлог (40),
7. Тухайн мэргэжлийн цалин (32),

8. Гэр бүлийнхний мэргэжлийн талаарх ойлголт (33),
9. Гэр бүлийнхний жендэрийн хэвшмэл ойлголт (31),
10. Тухайн мэргэжлээр дадлагажсан байдал (28).

4.2. Багшийн мэдлэг, чадвар, хандлага сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлөх нь

Багш хичээлийн агуулгыг хэрхэн заадаг байдал, мэргэжлийн талаарх ойлголт, сурагчидтайгаа хэрхэн харилцаж буй хандлага нь хүүхдийн мэргэжил сонголтод голлох нөлөөтэй байна. Тухайлбал багш өөрийн хичээлийг сайн зааж, тухайн хичээлийг сонирхох хүүхдийн сонирхлыг өдөөх тусам хүүхдүүд тэрхүү хичээлтэй холбогдолтой мэргэжлийг сонгох сэдэл нэмэгддэг нь ажиглагдлаа. Энэ тухай судалгаанд оролцогч сурагч (О-12) хэлэхдээ:

“...Манай биологийн багш хичээлээ маш сайхан заадаг байсан. Багшийгаа харах төдийд л хүүхдүүд биологидоо дуртай болдог. Би биологич, био-технологич тал руу явъя ч гэж бодож байсан. Даан ч багш солигдоод хичээлээ ойлгохоо больчихсон...”

хэмээсэн нь багшийн заах арга барил хүүхдийн мэргэжил сонголтод нөлөөлдөг болохыг илтгэж байна. Эндээс харахад багш нар хичээлийн агуулгыг заахаас гадна сурагчидтай харилцах харилцаанд гаргадаг хандлага хүүхдийг тухайн хичээлийг сонирхох, гүнзгийрэн судлах хүсэл сонирхолд нөлөөлснөөр мэргэжил сонголтод дам нөлөөлж байна. Энэ харилцаа хандлагын хүрээнд “сэтгэл чухал” болохыг сурагч (О-12) дараах байдлаар тодорхойлжээ:

“...Одоо байгаа ангийн багш маань сэтгэлгүй. Би багш байсан бол жаахан ч гэсэн илүү юм хэлж өгөөд, хүүхдүүдээ амжилт гаргахад нь тусалж дэмжээд явах юм бол тэр нь надад амжилт юм шиг санагдана. Энэ бодлоо гэхдээ орхихгүй, цалин нэмэгдэх л юм бол багш болно гэж боддог...”

Зарим тохиолдолд багш нарын хандлага хүүхдийн хүсэл, мөрөөдлийг хэрхэн няцааж, өөртөө итгэх итгэлийг бууруулж байгаа жишээг орон нутгийн суралцагч (О-33) дараах байдлаар тодорхойлжээ:

“...Багш нарын хандлагаас болж бас нөлөөлж болно. Багш чи энийг чадна, эсвэл чамд энэ тохирохгүй гэх мэтээр хэлэхэд хүүхэд өөртөө итгэлгүй болдог...”

Эндээс харахад багш нар хүүхэдтэй ажиллахдаа маш болгоомжтой ажиллах, хичээлээ хүүхдийн сонирхлыг өдөөхүйц заах шаардлагатайг харуулж байна. Мөн багш нар зөвхөн хичээлийн агуулгыг хүргэх бус ямар мэргэжлээр сурч болох боломжийн талаар мэддэг байх нь чухал байна. Улаанбаатар хотын захын дүүргийн нэгэн сурагч (О-6) хэлэхдээ:

“...Хичээлээсээ улбаалаад салбарлах боломжтой мэргэжлүүдийг сайн мэдэхгүй. Багш нараасаа асуухаар сайн хэлж өгч чаддаггүй. Төвийн сургуулиудад гадагшаа явах, цаашаа сурах мэдээлэл, эссэ бичих гэх мэт ойлголтыг өгч, дэмжлэг тусалцаа үзүүлдэг. Гэтэл манайх шиг захын сургуулиудад иймэрхүү мэдээлэл, дэмжлэг бараг л байдаггүй...”

гэсэн нь багш нар салбар мэргэжлүүд, хэрхэн их сургуульд элсэх, эссэ бичих талаар мэдээлэл өгдөг байхын чухлыг онцолж, алслагдмал дүүрэгт багш нар энэ талаар сайн мэддэггүй байх хандлагатайг илэрхийлжээ. Үүнийг Улаанбаатар хотын өөр нэгэн сурагч (О-7) хэлэхдээ:

“...Улсын сургууль гэдэг утгаараа манай сургуулиас гадагшаа явах бололцоо муутай. Наад зах нь багш, нийгмийн ажилтнаараа “supplement essay” [өөрийн давуу тал, тухайн сургуулийг яагаад сонгосон зэрэг тодорхой асуултыг хөндсөн эссэ] гэх мэтийг бичүүлье гэхээр тэр талаар огт мэддэггүй...Багш нар төдийлөн зөвлөгөө өгдөггүй. Би 11-р ангидаа байхдаа “над шиг эргэлзэж байгаа олон хүүхэд байгаа, сургуульд зөвлөгөө чиглүүлэг дутмаг учраас би сургалт ормоор байна гэж хэлж үзсэн...”

хэмээсэн нь мэргэжил сонголтын талаарх мэдээлэл, дэмжлэг дутмаг, багш нар энэ чиглэлээр хангалттай чиглүүлж чадахгүй байх тохиолдол түгээмэл, сурагчид төөрөгдсөн байдалтай байгаа нь анзаарагдлаа. Мэргэжил сонголт тодорхойгүй тул хичээл сонголт нь цалгардах хандлага мөн ажиглагдаж байна. Сурагчдын мэргэжил сонголт гэдэг нь зөвхөн ямар нэг хичээлийг гүнзгийрүүлж судлаад их сургуульд элсэх гэхээс илүүтэй түүний урьдач нөхцөл болох мэргэжлүүдийн талаарх ялгааг таних, эссэ бичих, өргөдөл гаргахад бэлтгэх мэдлэг, чадвартай байхыг шаардаж, багш нар сурагчдынхаа эдгээр хэрэгцээ шаардлагад хүрч ажиллахдаа учир дутагдалтай байгааг анхааруулж байна.

4.3. Багшийн жендэрийн хэвшмэл ойлголт ба мэргэжил сонголт

Сургуулийн орчинд жендэрийн хэвшмэл ойлголт сурагчдын мэргэжил сонголтод хэрхэн нөлөөлж байгаа талаар багш нарын зүгээс гаргаж буй хандлагыг сурагчид хэрхэн тайлбарлаж байгаа болон судалгаанд оролцогч багш нарын үзэл бодолд үндэслэн шинжлэхэд жендэрийн хэвшмэл ойлголт сурагчдын мэргэжил сонголтод зарим талаар нөлөөлж байна.

Багш нар хүүхдийн мэргэжил сонголтод хэрхэн жендэрээр ялгаатай ханддаг талаар орон нутгийн дунд сургуулийн ахлах анги даасан 14 жилийн туршлагатай эмэгтэй багш (Багш-1)-ийн хэлснээс харж болохоор байна:

“Тооцоолон бодох чадвар сайтай, гүйлгээ ухаантай ч гэдэг юм уу эрэгтэй хүний нэг тийм чадварууд байгаад байдаг. Охидуудад арай нэг жоохон дутмаг... Тиймэрхүү юман дээр угаасаа яалт ч үгүй хүйсийн ялгаа харагдаад байдаг юм байна лээ... Охидын хувьд бол эмэгтэй хүний байгалийн нэг юм байдаг даа. Зөөлөн ур чадвар илүү ... нарийн мэргэжлийн юмнууд эмэгтэй хүүхдүүд түлхүү харж сонговол тэр нь дээр, амжилт гаргах нь илүү болоод байгаа юм” гэжээ.

Уг багшийн бодлоор хөвгүүд тооцоололд сайн охид зөөлөн ур чадвартай тул хүнтэй харилцах мэргэжилд тохирно хэмээн үзэж байгаа нь жендэрийн хэвшмэл ойлголт хэмээн үзэж болохоор байна. Угтаа тооцоолол, хүнтэй харилцах харилцаанд жендэрийн ялгаа байх үндэсгүй юм. Улмаар өөр нэгэн багш (Багш -1) байр сууриа илэрхийлэхдээ:

“Нарийн чимхлүүр, техник биш, хүнтэй харилцах тал руугаа... жишээ нь эмч байдаг юм уу, яалт ч үгүй хүнтэй харилцана. Багш, сэтгэл зүйч, сэтгүүлч байна. Нийгмийн, олон нийт рүү чиглэсэн юмыг нь болохоор охидууд илүү түлхүү сонгоод байгаа. Тэгээд тэрэндээ ч бас илүү амжилт гаргадаг юм болов уу гэж хараад байгаа” гэжээ.

Эндээс дүгнэхэд охидын зөөлөн ур чадварыг хүнтэй харилцах мэргэжилд тохирно хэмээн үздэг хандлага багш нарын дунд ажиглагдлаа. Тухайлбал уг багшийн даасан ангийн сурагчид дунд математик, физик суурьтай хичээлүүдийг сонгон судалж инженер, мэдээллийн технологийн мэргэжлүүдийг сонгосон 4 сурагчийн 3 нь эрэгтэй, 1 нь эмэгтэй сурагч байна. Үүнээс харахад мэргэжил сонголтод инженерийн мэргэжлийг охид сонгох байдал хөвгүүдийнхээс 4 дахин бага байна. Мөн Солонго нар (2019)-ын судалгаагаар их дээд сургуулийн багш нарын дунд эрэгтэй, эмэгтэй сурагчид байгалиасаа *“оюун санаа, сэтгэн бодох ур чадвар ялгаатай заяагдсан”* хэмээх хэвшмэл ойлголттой багш цөөнгүй байгаагаас гадна жендэрийн талаарх ойлголт муу байгааг онцолжээ (Солонго, et al., 2019).

4.4. Сурагчид жендэрийн хэвшмэл ойлголтыг сөрж буй нь

Судалгаанд хамрагдсан сурагчдын мэргэжил сонголтод жендэрийн хэвшмэл ойлголт голлох нөлөөгүй байгааг аймгийн төв, сумын төв, хотын сургчдын хэлж байгаагаас харж болохоор байна. Ялангуяа мэргэжилд хүйс байхгүй, хүйсээр бус чадвар, сонирхлоороо мэргэжлээ сонгохын чухлыг сурагчид онцолж байлаа. Тухайлбал Говь-Алтай аймгийн ахлах ангийн бизнесийн чиглэлээр мэргэжил сонгосон эрэгтэй сурагч (ГАА-40-42) хэлэхдээ:

“Жендэрээр ялгаварласан хандлагад дургүй. Эрэгтэй байж цагдаа, эмэгтэй байж эмч гэдэг бол буруу. Манай улс, нийгэм нь өөрөө тийм ойлголттой байгаад байдаг. Тиймээс хүн бүр тийм ойлголттой байдаг. Гадаад орнуудад бол ойлголт нь өөр байдаг болохоор хүйсийн талаарх ойлголт нь өөр байдаг” гэжээ.

Энэ нь орон нутгийн сурагч жендэрийн хэвшмэл ойлголттой санал нийлэлгүйгээр мэргэжлээ сонгох хандлагатай байгааг илтгэж байна. Үүнийг улам бататгаж ГАА-ийн сэтгэлзүйчээр сурахаар шийдсэн эмэгтэй сурагч (ГАА-1-2) хэлэхдээ:

“Хүйсээс хамаарч мэргэжил сонгох нь буруу гэж бодож байна. Техник технологи хөгжсөн байхад заавал хүйсээс хамаарч мэргэжил сонгоно гэдэг ойлголт байхгүй.”

Хэмээсэн нь орчин үед технологийн боломж жендэрийн эрх тэгш нөхцөлд мэргэжил сонгож ажиллах боломжийг дэмжиж буйг онцолжээ.

Улаанбаатар хотын улсын сургуулийн 12 дугаар ангийн эрэгтэй сурагч (О-1) бизнесийн мэргэжил сонгосон бөгөөд жендэрийн хэвшмэл ойлголтын талаар дурьдахдаа:

“Би ер нь хүний тиймэрхүү [жендэрийн хэвшмэл ойлголт] зөвлөгөө, хүсэл сонирхлыг харгалзаагүй, саналыг хүлээж авах дургүй. Эрэгтэй хүн байсан ч эмч болог л дээ...Эр, эм хүмүүс хэн нь ч ажил хийдэг байсан яах вэ. Аль боломжтой нь хүүхдээ харж, гэрийн ажлаа хийж, мөнгөө олох хэрэгтэй...”

гэсэн нь сурагчид жендэрийн хэвшмэл ойлголтод баригдах дургүй, эрх тэгш байх ёстойг чухалчилжээ.

Үүнтэй санал нийлж буй Улаанбаатар хотын улсын сургуулийн XI ангийн эмэгтэй сурагч (О-2) онгоцны нисгэгч мэргэжил сонгосон бөгөөд жендэрийн хэвшмэл ойлголтын талаар дурьдахдаа:

“Онгоцны нисгэгч болно гэж боддог. Эмэгтэй хүмүүс энэ мэргэжлийг сонгох нь ховор... Эрэгтэй нь ганцаараа мөнгө олж, гэрийнхнээ тэжээх албагүй. Эмэгтэй хүн ч адил өндөр цалин авч, ар гэрээ авч явах боломжтой, тэр нь ч дээр санагддаг. Эрэгтэйчүүд хүссэн ажилдаа явж, харин эмэгтэйчүүд гэртээ л байгаад байх нь надад таалагддаггүй... Ер нь ийм бодол буруу л санагддаг. Учир нь эрэгтэй, эмэгтэй хүнийг ялгаатай байгаасай гэж боддоггүй. Адилхан л эрхтэй, адилхан л хүмүүс шүү дээ. Багаасаа толгойд суусан бодлоос болоод би эрэгтэй болж төрсөн болоосой гэж хааяа боддог. Яагаад ч юм гэрийнхэн үргэлж л “Чи охин байж ингэх ёстой, тэгж болохгүй, ингэж ч болохгүй” гэдэг нь ядаргаатай байдаг. Хүйсэнд ямар ялгаа байна аа ” гэсэн байна.

Түүний хувьд жендэрийн хэвшмэл ойлголт бага наснаас хэвшдэг, эрэгтэй байхын давуу талыг мэдэрч байсан ч үүнийг сөрж мэргэжлээ сонгосон нь анзаарагдаж байна. Тиймээс эрэгтэй эмэгтэй хүмүүсийн үүрэг ижил гэж үзэн, эмэгтэй хүний хүсэл сонирхлыг “хайрцагласан” хэвшмэл хандлагаас ангид байх шийдвэр гаргажээ.

Жендэрийн хэвшмэл ойлголтыг сөрж архитектор мэргэжлээ сонгосон өөр нэгэн жишээ Улаанбаатар хотын олон улсын сургуулийн 12 ангийн охины жишээгээр баяжиж байна. Түүний (О-8) хэлснээр:

“Эмэгтэй хүнд тохирохгүй гэж нэлээн их сонсож байсан. Эмэгтэй хүн гэртээ их цаг зарцуулах хэрэгтэй болохоор. Жишээ нь хүүхдээ харах, гэрээ цэвэрлэх, хоолоо хийх гэх мэт иймэрхүү ажилд цагаа зарцуулах нь түлхүү болохоор, архитектур нь 7, 14 хоногоор ачаалалтай, гэрээсээ хол байдаг болохоор эмэгтэй хүнд тохирохгүй гэдэг байх. Гэхдээ миний хувьд энэ нь хамаагүй ээ. Гэр орон гэж бодохгүй байгаа болохоор. Гэр бүлтэй болчихвол аль алиныг л нь л зохицуулах гэж хичээх байх” гэжээ.

Энд дурдагдаж буй жендэрийн хэвшмэл ойлголт нь тухайн мэргэжилд эмэгтэй хүн нийцэхгүй байх шалтгааныг ахуйн хүрээний эмэгтэй хүнд оногддог үүргүүдтэй холбож тайлбарлажээ. Хэдийгээр жендэрийн хэвшмэл ойлголтыг сөрж мэргэжлээ сонгосон ч жендэрийн хэвшмэл ойлголт, түүнээс үүдсэн үүргийг үгүйсгээгүй байна.

Энэ бүхнээс дүгнэхэд хот, аймгийн төв болон улсын, хувийн, олон улсын сургуульд ялгаагүй жендэрийн хэвшмэл ойлголтыг мэргэжил сонгоход буруушаасан хандлага сурагчдын дунд олон байна. Ялангуяа охид жендэрийн хэвшмэл ойлголтыг сөрж, өөрийн хүслээр мэргэжлээ сонгож байхад, хөвгүүд ч ялгаагүй жендэрийн үүргийг эрх тэгш байлгах, мэргэжилд хүйсээр ялгаварлахгүй байхын чухлыг онцолжээ.

4.5. Гэр бүлийн орчны жендэрийн хэвшмэл ойлголт сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлөх нь

Гэр бүлийн орчны жендэрийн хэвшмэл ойлголт сурагчдын мэргэжил сонголтод хэрхэн нөлөөлж байгааг судлаачид илрүүлэн шинжлэхэд хэд хэдэн ялгаатай нөхцөл байна. Зарим сурагч жендэрийн хэвшмэл ойлголттой тулгарахад түүнээс ангид байдлаар өөрийн хүсэл сонирхол, сонголтдоо өөрчлөлгүй сонголт хийж, түүгээр ч барахгүй тэрхүү сонголт нь зөв байсан гэдэгт итгэл дүүрэн сурч, төгсөж, хөдөлмөрлөж байгаа жишээ байсан бол зарим нь эсрэгээрээ тэрхүү хэвшмэл ойлголтод баригдан мэргэжлээ сонгосон байна.

Дээрх дүгнэлтийг бататгах нэгэн жишээ нь ГАА-ийн төвийн эмэгтэй сурагч (О-47)-ийн жишээ байсан ба тэрээр:

“Манай ах эмэгтэй хүүхдэд эмч их гоё харагддаг гэж хэлж байсан. Аавын найзууд чи хэл амтай юм чинь өмгөөлөгч, хуульч болооч гэдэг байсан.”

гэсэн нь гэр бүлийн орчинд эмэгтэй хүүхдийн талаарх ерөөсгөл ойлголтыг тодорхой нэг мэргэжилтэй холбож байгаа нь ажиглагдлаа. Үүнийг бататгах өөр нэгэн тохиолдлыг Улаанбаатар хотын 12-р ангийн сурагч охин (О-4) ийнхүү ярьжээ:

“Би Х ангиасаа юмш физиктээ дуртай байсан. Эргэн тойрныхон намайг физикээр яах гээд байгаа юм бэ, ямар эрэгтэй хүүхэд биш дээ, юу болно гэж физик үзээд байгаа юм, бараг эрэгтэй хүн болох гээд байгаа юм уу гэж шүүмжилж байсан. Учир нь хамаатны ах нар бүгд л физикт суурилсан шалгалтаа өгч, түүндээ тулгуурлан мэргэжлүүдээ эзэмшсэн.”

Эндээс үзэхэд хөвгүүд, охидын хичээл сонголт болон түүнтэй холбоотой мэргэжлийн талаар хэвшмэл ойлголт байсаар байгаа нь ажиглагдлаа. Энэ нь цаашлаад зарим охидын хувьд өөрийн хүссэн мэргэжлээр сурах боломжийг боомилж байна. Энэ талаар Улаанбаатар хотын XII ангийн сурагч охин (О-6) гэр бүлийн жишээг хуваалцжээ:

“Том эгч маань жүдогоор барилддаг. Цаашид жүдогоороо яваад, биеийн тамирын багш болно оо гэхэд “Эмэгтэй хүүхэд хэзээ биеийн тамирын багш болж байсан юм” гээд аав, ээж болиулж байсан.”

Энэ тохиолдол нь зарим эцэг, эх өөрсдийн жендэрийн хэвшмэл ойлголтоор хүүхдийн сонголтод нөлөөлж байгааг харуулж байна.

Гэхдээ жендэрийн хэвшмэл ойлголтын нөлөө буурч байгаа тал ажиглагдлаа. Энэ талаар аймгийн төвийн сургуулийн нийгмийн ажилтны (Нийгмийн ажилтан-2) хэлснээс үзвэл:

“... Одоо ер нь хүйсээс хамаарч мэргэжил сонгох гэдэг ойлголт бараг л байхгүй болсон. Ер нь л бүгд сайн суръя, мэргэжилтэй болох талаар боддог болсон.”

гэсэн нь сурагчид хүйсээс хамаарч мэргэжил сонгохдоо биш, яаж амжилттай сурч төгсөх талаар илүү анхаардаг болсон нь анзаарагдаж байна. Судалгааны явцад мэргэжил сонголтод жендэрийн хэвшмэл ойлголт зарим нэг оролцогчид байсан ч дийлэнх оролцогч багш, эцэг, эх, сурагчдын төлөөлөл жендэрийн хэвшмэл ойлголт мэргэжил сонголтод нөлөөлөөгүй гэж үзжээ.

Харин Улаанбаатар хотод суралцагч XII ангийн хөвгүүн (О-12) хэлэхдээ:

“Амьдралд хамгийн ойрхон жендэрийн санал нийлэмгүй асуудал бол гэр бүлийн доторх асуудал юм. Эрэгтэй нь л мөнгө их олж, эмэгтэй нь гэртээ хүүхдээ хараад байж байх ёстой гэх мэт... Эр, эм хүмүүс... ажил, хөдөлмөр, оюун ухаан, чадамжаараа эн тэнцүү, эрх тэгш байх ёстой. Хүнийг үнэхээр ажил хөдөлмөрийн талбар дээр үнэлэх гээд байгаа бол туршлагаар нь л үнэлж цэгнэх хэрэгтэй...”

гэж байгаагаас харахад гэр бүлийн орчинд эрэгтэй хүүхдэд илүү ачаа үүрүүлж, эмэгтэйүүдийг гэр бүлийн асрах, халамжлах зэрэг цалингүй ажил хийж ёстой мэтээр ханддаг ч ахлах ангийн хүүхдүүд үүнтэй санал нийлэлгүй хүйсээр бус, чадвараар нь үнэлэх ёстойг онцолж байгаа нь өсвөр насныхны дунд жендэрийн хэвшмэл ойлголтын нөлөө багасч байгааг илтгэж байна.

4.6. Сургуулийн орчин: Багш, сургалтын хөтөлбөрийн ялгаварлал ба күйр сурагчид

Судалгаанд хамрагдсан ЛГБТИК+ олон нийтийн төлөөллийн хувьд мэргэжил сонголт нь бусад сурагчидтай харьцуулахад илүү олон буюу тогтолцооны болон бусад саад тотгорыг даван туулж байж хийгддэг, эсхүл төрөл бүрийн ялгаварлалаас улбаалж сурч боловсрох эрх нь хангагдахгүй байх талтай байна. Сургуулийн орчинд багш нарын харилцаа, хандлага болон сургуулийн дүрэм журмууд нийгэмд хэвшсэн байнари тогтолцоонд хашигдсан хэвээр байгаа нь күйр сурагчдын онцлог байдлыг огоорч, суралцахад таагүй, тухгүй байдлыг үүсгэсээр байна. Ялангуяа зарим багш нарын жендэрийн хэвшмэл ташаа ойлголт, күйр сурагчдын оршихуйг үл хүндэтгэсэн ялгаварлал, зарим тохиолдолд доромж харилцаа нь тэдгээр сурагчдын өөртөө итгэх итгэл, суралцах идэвх, нэр төр, мэргэжил сонголтод дам нөлөөлсөөр байна. Сургуулийн дүрэмт хувцасны журам, хүйсээр заагласан хичээлийн хөтөлбөр зэрэг нь күйр сурагчдын хүсэл, сонирхол, хөгжих боломжийг хязгаарласан хэвээр байна.

Багш нарын харилцаа хандлагын талаар Улаанбаатар хотод XII ангид суралцагч нонбайнари күйр сурагч (Н-3) хэлэхдээ:

“Багш нарт дутагддаг зүйл бол үзэл бодлоо өөрчилж, өөр өнцгөөс харах, хүлээн зөвшөөрөх чадвар юм. VII ангид би урт үстэй байж байгаад, анх удаа богино халимаг үстэй болсон. Надад маш дуртай байсан багш маань их дургүйцэж, эсэргүүцсэн. “Багш аа би өөрийнхөөрөө баймаар байна” гэж хэлснээс хойш надтай дугарахаа больж, сайн байна уу гэж мэндлэхэд ч тоохоо больсон...”

гэснээс дүгнэхэд күйр сурагчдыг ялгаварлах, өөрийнхөө оршихуйг хүлээн зөвшөөрч байгаа байдлыг нь “эсэргүүцэх” хандлага багш нарын дунд байсаар байна. Хэдийгээр энэ нь хэр түгээмэл тохиолддогийг мэдэх боломжгүй ч сургуулийн болон гэр бүлийн орчинд төрөл бүрийн ялгаварлал, дээрэлхэлтэд түгээмэл өртөж байдаг талаар зарим судалгаа онцолсон байдаг. Тухайлбал, Монгол дахь ЛГБТ хүүхдүүдийн дунд хийгдсэн судалгаагаар 79 хувь нь жендэрийн болон хүйсийн баримжаа, илэрхийлэмжээс болж ямар нэг төрлийн ганцаардуулалт, ялгаварлалыг туулж байсан бол 45.16 хувь нь гэр бүлийн орчинд хүчирхийлэл, гадуурхалт, ганцаардуулалтыг мэдэрч, туулж байжээ (LGBT Centre, 2019). Энэ ялгаварлал нь күйр сурагчдыг сургуулийн орчинд сурч, хөгжих эрхээр хангагдахгүй болгож байгааг онцлоод Монгол Улсын засгийн газраас хангалттай арга хэмжээ авахгүй байгааг цохон тэмдэглэжээ (LGBT Centre, 2019).

Сургуулийн орчны дарамтын талаар Улаанбаатар хотод ахлах ангид суралцдаг трансжендэр эмэгтэй сурагч (НО-5) хэлэхдээ:

“Өвөө, эмээ дээрээ уулын модонд амар амгалан... маш эрх дураараа өссөн... маш их хайрласан. Одоо ч тэр, миний гадаад төрх өөрчлөгдсөн байхад, маш сайхан харьцсан хэвээр л байдаг... Мэргэжил сонголтын тухайд дотоод хүн маань мэргэжлээ ч сонгож чадахааргүй хүн шүү дээ. Шилжилтэд орохын өмнө маш их дарамтад орж байсан, харин одоо бол багасаж байна. Бараг л [хичээлдээ] ирдэггүй болсон. Тийм болохоор энэ бүхэн зөөлөн байгаасай л гэж хүсэж байна. Өөрийн зүгээс чадах зүйлээ хийхийг хичээж байгаа...” хэмээжээ.

Энэ нь трансжендэр сурагч байснаараа маш их дарамтыг туулж, сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүйд хүрч, улмаар мэргэжлээ сонгож чадахааргүй хэмжээнд байгааг дурджээ. Энэ нь зарим күйр сурагчид, тэр дундаа трансжендэр байх нь бусад күйр сурагчдаас илүү бэрхшээлтэй тулгардаг байж болохыг харуулж байна. Тэдний хүсэл сургуулийн орчин “зөөлөн” байгаасай хэмээж буй нь элдэв дарамт, ялгаварлалгүй, хүн ёсны харилцаа үгүйлэгдэж байгааг илэрхийлжээ. Күйр сурагчид сургуулийн орчинд бусад сурагчдаас илүү олон бэрхшээл, жендэрийн хэвшмэл хандлагыг даван туулж мэргэжлээ сонгох болж байгаа нь боловсролын тогтолцоо, сургуулийн захиргаа, багш нараас илүү хүний эрхийн мэдрэмжтэй, жендэрийн ялгаатай байдалд нийцсэн ажлын арга барил, хандлагыг шаардаж байна. Энэ талаар дээрх трансжендэр сурагч (НО-5) ийнхүү ярьжээ:

“Хөдөлмөрийн хичээл дээр хүйсээр ялгаж оруулдаг хэвээрээ, биеийн тамир дээр ялгадаг хэвээрээ... Дүрэмт хувцасны хувьд ч охид заавал юбка өмсөх ёстой гэх мэт ангилах нь хэцүү байдаг. Өмд өмсөөр байгаа өчнөөн л охид байна. Үүнийгээ хэлэхээр сургуулийн дүрэмд заасан хувцсаа л өмс гэдэг. Тэр цаад дүрэм гаргаад байгаа хүмүүс л мэдлэггүй, мэдрэмжгүй байх шиг санагддаг”.

Сургуулийн дүрэм, журмаар далайлгаж хүний оршихуйг хүчээр үгүйсгэж, сонголт өгөхгүй байснаараа сургуулийн захиргаа дам хүчирхийлэл, ялгаварлалыг үйлдэж, транс сурагчдыг ялгаварлаж байгаа нь харагдаж байна. Үүний шалтгааныг “мэдлэггүй, мэдрэмжгүй” эрх мэдэлтэн, албан тушаалтан хэмээн онцолж байгаагаас дүгнэвэл сургуулийн удирдлагууд, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны бодлого, шийдвэр гаргагчид анхаарах цаг болсныг харуулж байна.

Ялангуяа биеийн тамир болон хөдөлмөрийн (технологийн) хичээлүүдийг хүйсээр заагласнаар сурагчдын сурах сонголтыг хөсөрдүүлж, байнари хүйсийн хүрээнд хүчээр судлахад хүргэж байна. Энэ нь цаашлаад жендэрийн хэвшмэл ойлголтыг сургалтын хэлбэр агуулгаар дамжуулж улам батжуулж буй хэлбэр юм. Энэ талаар судалгаанд оролцогч күйр төлөөлөл (НО-6) хэлэхдээ:

“Хөвгүүдийн хөдөлмөрийн хичээл рүү оръё гэж би 3 жилжингээ гуйсан...Би модоор юм зорж, дүүдээ машин хиймээр байсан. Гэртээ өөрөө хийе гэхээр боломж, тоног төхөөрөмж нь байгаагүй. Ер нь зүгээр л багш нарын хандлага нь л тийм байсан...” гэжээ.

Энэ нь охид ч ялгаагүй хөдөлмөрийн хичээлийг өөрийн хүслээр судлах хэрэгцээтэй болохыг илтгэж байна. Шалтгаан нь охидын судалдаг хичээлийн агуулга күйр сурагчдын онцлогтой зарим талаар нийцдэггүй, күйр сурагчид жендэрийн хэвшмэл хандлагатай санал нийлдэггүйтэй холбоотой байх тал харагдаж байна. Зарим багш нар хүйсийн болон бэлгийн баримжааны талаар ташаа ойлголтойн улмаас хүүхдийг гадуурхсан үг хэлээр ярьж, тэр хандлага нь магад тэдний жендэрээр ялгасан хичээлийн агуулгыг судлахад саад болох хүчин зүйл байж болохыг “3 жилжингээ гуйсан” гэх дээрх жишээ харуулж байна. Энэ бол багш нарын хандлагаас шууд хамаарч байгааг судалгаанд оролцогч дурьджээ. Тэрээр цааш багш нарын жендэрийн хэвшмэл ойлголт, хандлага хэрхэн охидын боломжийг хязгаарлаж байгаа талаар (НО-6):

“Гэхдээ нөгөө талаас ур чадвар ярих гэж байгаа бол өөр хэрэг. Судалгааны багтаа хүн авах гэж байгаа бол охидод боломж олгох хэрэгтэй. Багш нар хөдөө явах гэж байна гээд эрэгтэй хүүхэд авч явах гээд байдаг. Чадаж байгаа, чадахыг хүсэж байгаа зөндөө олон охид бий...”

гэсэн нь боловсролын салбар дахь тэгш боломж хүйсийн талаарх явцуу ойлголтын хүрээгээр хязгаарлагдаж байгааг харуулж байна. Суралцаж буй мэргэжлээ гүнзгийрүүлэн судалж, шинэ зүйл сурч мэдэх, өөрийн мэдэх зүйлээ ур чадвар болгох хүсэл тэмүүллийг энэ мэт хүйсээс хамаарсан явцуу хүрээнд шийдвэрлэх нь ирээдүйн чадварлаг боловсон хүчний тоог бууруулахаас эхлээд, нийгмийн дунд ялгаварлан гадуурхалтын суурь үндсийг тавьж буй хэрэг юм. Энэ нь судалгаа шинжилгээ, ажлын байрны орчинд сонгон шалгаруулалт зохион байгуулахдаа хүйсийн тэнцвэрт байдлыг харгалзан үзэх, хувь хүний ур чадварт суурилах хэрэгтэйг сануулж байна.

4.7. Сургуулийн орчны эерэг хандлага ба күйр сурагчид

Хэдийгээ күйр сурагчдыг ялгаварлах хандлага түгээмэл байдаг ч зарим сургууль, багш нарын хандлага күйр сурагчдад ээлтэй байгааг судалгаанд оролцогчид хуваалцжээ. Улаанбаатар хотын хувийн сургуулийн гей сурагч (НО-4) энэ талаар ийн өгүүлжээ:

“Манай сургуульд багш нар нь сурагчидтайгаа нээлттэй харилцдаг. Яг л ээж шиг байдаг... Манай сургуульд хүйсээр ялгаварлан гадуурхалт төдийлөн ажиглагдаагүй. Сургуулийн маань тавны нэг нь л хөвгүүд. Гей гэдгийг маань захирал маань мэддэг. “Энэ талаар сургууль дээрээ бодохгүй бай” гэж хэлсэн”.

Энэ нь олонх сургуульд түгээмэл бус хандлага байж болох ч багш нар, сургуулийн удирдлагууд күйр сурагчдын үзэл бодлыг сонсож, тухтай мэдрэмжийг төрүүлж байгаа эерэг жишээ юм. Үүнтэй төстэй өөр нэгэн жишээг Улаанбаатар хотын улсын сургуульд XII ангид суралцагч нон-байнари күйр сурагч (Н-3) хэлэхдээ:

“...тэр байдлыг [ялгаварлагдсан] маань ойлгосон ганц л багш байсан нь... эмэгтэй багш. Намайг бусад эрэгтэй багш нар хоорондоо ярих үед тэд нараас хамгаалж, “би ч гэсэн багадаа ийм л дуртай зүйлээ хийдэг хүүхэд байсан” гэж хэлдэг. Тэр нь намайг хүлээн зөвшөөрсөн мэдрэмж төрүүлж, гоё байсан. Монтажны зурагт эрэгтэй, эмэгтэйгээрээ сууж зурагаа авахуулдаг юм л даа. ...би анх удаа эрэгтэй сурагчдын эгнээнд орж зургаа даруулсан. Би багш руу хараад, за яах л бол доо гэж бодтол, багш инээгээд л өнгөрсөн. Эрэгтэй, эмэгтэй аль алинтай нь хамт авахуулсан нь надад сайхан байсан” гэжээ.

Багш нарын бага ч атугай дэмжлэг эдгээр сурагчдад ямар их итгэл, найдлага, хүлээн зөвшөөрөгдсөн мэдрэмж, тухтай орчныг үүсгэж байгаа нь сайшаалтай. Энэ нь күйр сурагчдыг хүсэл, сонирхлоороо мэргэжлээ сонгох боломжийг бүрдүүлж байна.

Сурагчид өөрсдөө сургуулийн орчинд жендэрийн хэвшмэл ойлголтыг халахад хэрхэн идэвхийлсэн оролцож байгаа талаар Улаанбаатар хотын улсын сургуулийн трансжендэр эмэгтэй сурагч (НО-5) хэлэхдээ:

“Манай сургууль эрүүл мэндийн тал дээр маш чөлөөтэй байдаг. Гей байсан ч, лесби байсан ч хэн ч шүүмжилж, доромжилдоггүй. Одоо ийм чөлөөтэй байгаа байдлыг би суурийг нь тавилцсан гэж боддог. Би ганцаархнаа анх хамгийн анх хашгирч, тэмцэж, хүмүүсийн цочроог гаргачихсан. Одоо бол багш нар иймэрхүү зүйл дээр гайхахаа больсон.” гэжээ.

Энэ нь хүүхдүүд ч бас энэ хэвшмэл хандлагыг өөрчлөхөд нөлөөлж, ялгаварлалгүй сургалтын орчныг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулж байгаа сайн туршлага болж байна. Хэн нэгэн энэ мэт ялгаварлалыг үл хүлцэн, хэлж, ярьж таниулж байснаараа күйр сурагчдын сурах орчин илүү хүртээмжтэй, элдэв ялгаварлалаас ангид байх суурийг буй болгох боломжтойг харуулж байна.

5. ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнд хэд хэдэн ялгаатай үр дүн илрүүлснийг дараах байдлаар нэгтгэн дүгнэж байна.

- Сургуулийн орчинд багш нар сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлөх нөлөө давамгайл байсан бөгөөд багш нарын заах арга барил, хандлага, жендэрийн хэвшмэл ойлголт хүүхдүүдийн мэргэжил сонголтод тодорхой нөлөөтэй байна. Хичээлээ сонирхолтой, хүртээмжтэй заадаг, хүүхдэд ээлтэй хандлагатай багшийн хичээлээр суурилж мэргэжлээ сонгоход жендэр харгалзахгүй байна. Харин багш жендэрийн хэвшмэл ойлголттой бол ялангуяа инженерийн чиглэлээрх мэргэжилд хөвгүүдийг, хүнтэй харилцах харилцаа шаардсан мэргэжилд охидыг голлон чиглүүлж байгаагаас инженерийн чиглэлээр мэргэжлийг сонгосон 4 хүүхэд тутмын 1 нь эмэгтэй байв.
- Сурагчид жендэрийн хэвшмэл ойлголтыг хэвшүүлж, түгээж байгаа жишээ сургууль орчимд ажиглагдаж байна. Энэ нь ахуйн болон нийгмийн орчинд нөхцөлдсөн жендэрийн хэвшмэл ойлголт сургуулийн удирдлага, багш нарын өөр өөр хандлагатай хавсарч нэг бол батжих, эсхүл бүдгэрэх хандлагатай байна.
- Дунд сургуулийн биеийн тамир, хөдөлмөр (технологи)-ийн хичээлүүд хүйсээр ялгаж хичээллэж байгаа нь жендэрийн хэвшмэл ойлголтыг улам бэхжүүлж, хүйсийн ялгаатай баримжаатай күйр болон бусад сурагчдын мэргэжил сонголтыг байнари хүйсийн хүрээнд хязгаарлаж байна.
- Гэр бүлийн орчин сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлөгч анхдагч орчин болж байна. Орчин үед эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийн мэргэжил сонголтод хүндэтгэлтэй ханддаг тохиолдол түгээмэл ч багагүй хэсэг нь жендэрийн хэвшмэл ойлголтаар нөлөөлөх тал ажиглагдлаа. Харин хүүхдүүд ихэнх тохиолдолд хүссэн мэргэжлээрээ суралцах шийдвэрээ өөрсдөө гаргаж чадаж байна. Ялангуяа нийгмийн сүлжээгээр мэдээллийн хүртээмж сайжирснаар хүүхдүүд жендэрийн хэвшмэл ойлголтод хязгаарлагдах байдал нь улам багасч байна.
- Зарим күйр сурагчдын хувьд жендэрийн хэвшмэл ойлголттой уялдаж төрөл бүрийн ялгаварлал, дарамтад өртөж, сургуулийн зүгээс тогтоосон хүний эрхийн мэдрэмжгүй байнари дүрэм журам нь сургуулийн орчинд сурч боловсрох эрхийг нь зөрчиж байна. Улмаар хүссэн чиглэлээрээ суралцаж чадахгүй байх, эсхүл бусад сурагчидтай харьцуулахад давхар ялгаварлалыг сургуулийн орчинд даван туулснаар мэргэжлээ сонгож чадахгүй байдалд хүрч байна. Гэсэн хэдий ч зарим багш, сургуулийн удирдлагуудын хандлага күйр сурагчдад ээлтэй суралцах орчныг бүрдүүлж байгаа эерэг жишээ байгаа нь сургуулийн орчин жендэрийн хэвшмэл ойлголтыг бууруулах боломжтойг илтгэж байна.

Талархал

Энэхүү судалгааг санхүүжүүлсэн Азийн Сан, Канад улсын Засгийн газар, дэмжиж ажилласан Хөөрхөн Зүрх ТББ, ЛГБТ Төв, Бүх Нийт Боловсролын Төлөө Эвсэл, МонФемНет байгууллагын хамт олон, судалгаанд оролцогчид, эмпирик судалгааг гүйцэтгэсэн багийн гишүүн Д.Ариунтогос, А.Буянжаргал, Б.Цэнд-Аюуш нарт гүнээ талархаж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

Англи хэлээр

- Adele, A. E., & Wojciszke, B. (2007). Agency and communion from the perspective of self versus others. *Journal of personality and social psychology*, 93(5), 751.
- Alonso-Ruido, P., Estévez, I., & Varela-Portela, C. (2023). College Students' Stereotyped Beliefs. *Social Sciences*, 12(5), 302.
- Crenshaw, K. W. (1991). Mapping the margins: Intersectionality, identity politics, and violence against women of color. In *The public nature of private violence*. *Stanford Law Review*, 43(6), 1241-1299.
- Eagly, A. H., & Karau, S. J. (2002). Role congruity theory of prejudice toward female leaders. *Psychological review*, 109(3), 573.
- Ellemers, N. (2018). Gender stereotypes. *Annual review of psychology*(69), 275-298.
- Favara, M. (2012). The cost of acting 'girly': Gender stereotypes and educational choices. *IZA Discussion Paper*, 7037, 65.
- Ginzberg, E. (1972). Toward a theory of occupational choice. *Vocational guidance quarterly*, 20(3), 2-9.
- Golombok, S., & Fivush, R. (1994). *Gender development*. Cambridge University Press.
- King, T. L., Scovelle, A. J., Meehl, A., Milner, A. J., & Priest, N. (2021). Gender stereotypes and biases in early childhood: A systematic review. *Australian Journal of Early Childhood*, 46(2), 112-125.
- Kuhn, A., & Wolter, S. C. (2022). Things versus people: Gender differences in vocational interests and in occupational preferences. *Journal of Economic Behavior and Organization*, 203, 210-234.
- LGBT Centre. (2019). *Submission to the Human Rights Council at the 36th Session of the Universal Periodic Review: Mongolia*. Ulaanbaatar: LGBT Centre.
- Ritchie, J., & Lewis, J. (2006). *Qualitative research practice: A guide for Social Science Students and Researchers*. Sage publications.
- UNDP. (2021). *Integration of Gender Responsive Financing Practices in Mongolia's Financial Sector*. UNDP.
- UN. (2023). *Gender stereotyping: OHCHR and women's human rights and gender equality*. Retrieved August 2023, from <https://www.ohchr.org/en/women/gender-stereotyping#:~:text=A%20gender%20stereotype%20is%20a,personal%20abilities%2C%20pursue%20their%20professional>.

Монгол хэлээр

- Болдмаа, Н., Чанцалдулам, Р., Галиймаа, Н., & Одгэрэл, Б. (2019). *Дээд боловсролын элсэлтийн жендэрийн дүн шинжилгээ: судалгааны тайлан*. Улаанбаатар: Сод Пресс.
- Жендэрийн Үндэсний Хороо. (2020). *Монгол улс: жендэрийн тэгш байдлын өнөөгийн түвшин*. Улаанбаатар: Жендэрийн Үндэсний Хороо. [Цахим] <https://ncge.gov.mn/uploads/research/Gender%204%20new%20mon.pdf>. (Хандсан: 25.08.2023).
- Жендэрийн Үндэсний Хороо. (2022). *Монгол улс: жендэрийн тэгш байдлын өнөөгийн түвшин*. Улаанбаатар: Жендэрийн Үндэсний Хороо. [Цахим] <https://ncge.gov.mn/uploads/research/Gender%204%20new%20mon.pdf>. (Хандсан: 25.08.2023).
- Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр. (2021a). Монгол улсын санхүүгийн салбарт жендэрийн мэдрэмжтэй санхүүжилтийн аргачлалыг нэвтрүүлэх нь. НҮБХХ.
- Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр. (2021b). *Монгол улсад КОВИД-19 цар тахлын охид эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн амьдралд үзүүлж буй нөлөөллийн судалгаа*. Улаанбаатар: Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр.

- Солонго, А., Болдмаа, Н., Галиймаа, Н., Чанцалдулам, Р., Одгэрэл, Б., Одгэрэл, Ц., . . . Мөнхтуул, С. (2019). *Их дээд сургуулиудын ерөнхий суурь хичээлийн хөтөлбөрийн агуулгад хийсэн жендэрийн дүн шинжилгээ*. Улаанбаатар: Сод Пресс.
- УИХ. (2011). Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль. Монгол улс: <https://legalinfo.mn/mn/detail/253>.
- Үндэсний Статистикийн Хороо. (2023). *Хөдөлмөр эрхлэлтийн статистик Статистикийн мэдээллийн нэгдсэн сан*. . Улаанбаатар: [Цахим] <https://www.1212.mn/>. (Хандсан: 26.08.2023).
- Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Яам. (2018). Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Салбарт Жендэрийн талаар баримтлах бодлого. <https://www.ncge.gov.mn/uploads/legal/2018a94-%20ННААНУСJB.pdf>.